

**БУЛГАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА  
2026 ОНЫ 6 САР**

2026-07-08

Булган

2026 оны 6 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **41,2** тэрбум төгрөг буюу 100,6 хувийн, нийт зарлага **42,0** тэрбум төгрөг буюу 79,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

**1. Төсвийн орлого**

Нийт орлого ба тусламжийн дүн **41,2** тэрбум төгрөг буюу **100.6** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 12,6 тэрбум төгрөг буюу 23,5 хувиар, урсгал орлого 4,8 тэрбум төгрөгөөр буюу 11,6 хувиар тус тус буурсан байна. Улсаас авах санхүүгийн дэмжлэг, ОНХСангаас авах шилжүүлэ буурсан нь орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна. Тайлант оны урсгал орлогын гүйцэтгэл **35,1** тэрбум төгрөг буюу **104,8** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл (өссөн дүнгээр)	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт (ӨО-ны мөн үетэй харьцуулсан)	
		жилээр	тайлант үе (өссөн дүнгээр)		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5-4)	(5-2)	(5:2)
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>53,842.4</b>	<b>86,175.2</b>	<b>40,941.2</b>	<b>41,194.4</b>	<b>(253.2)</b>	<b>100.6</b>	<b>(12,648.1)</b>	<b>76.5</b>
Урсгал орлого	35,473.9	72,794.2	35,094.1	36,778.2	(1,684.2)	104.8	1,304.3	103.7
Татварын орлого	33,987.6	61,844.8	30,256.8	33,885.2	(3.6)	112.0	(102.4)	99.7
Татварын бус орлого	1,486.3	10,839.4	4,837.2	2,871.8	2.0	59.4	1,385.5	193.2
<b>Хөрөнгийн орлого</b>	112.3	110.0	-	21.3	<b>(0.0)</b>	-	<b>(91.0)</b>	<b>19.0</b>
<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын</b>	<b>12,233.3</b>	<b>13,380.9</b>	<b>5,847.2</b>	<b>4,416.1</b>	<b>1,431.1</b>	<b>75.5</b>	<b>(7,817.2)</b>	<b>36.1</b>
ОНХСангаас шилжүүлсэн орлого	8,947.6	10,666.9	4,490.2	3,059.1	1,431.1	68.1	(5,888.5)	0.0
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3,285.7	2,714.0	1,357.0	1,357.0	-	100.0	(1,928.7)	41.3

Нийт орлогын 10,7 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 82,3 хувийг татварын орлого, 7,0 хувийг татварын бус орлого эзэлж байна. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 17,5 тэрбум төгрөг буюу татварын орлогын 51,6 хувийг бүрдүүллээ. Аймгийн дүнгээр авч үзвэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, газрын төлбөр, ой, ус рашаан, ан амьтан, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, хөрөнгө борлуулсны орлого биелж бусад орлогын биелэлт 43,4%-96,5% байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 3,0 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг авч сумдад 2,2 тэрбум төгрөгийг олгосон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган аймагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гадаад зээлийн эргэн төлөлтийг орон нутгийн өмчит Булган мээж ХХК, Тэшиг ус ХХК-иуд эргэн төлөх чадваргүй байгаагаас зээлийн хүүгийн орлого тасарч байна.

Сумдын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **19,0** тэрбум төгрөг буюу **97,4** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2026 он төлөв.	2026 он 6 сар төлөв.	2026 он 6 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	748.4	320.4	365.2	-44.8	114.0
2	Баяннуур	578.7	292.5	270.3	22.2	92.4

3	Бугат	631.5	241.3	302.1	-60.8	125.2
4	Булган	12333.2	5628.6	5389.4	239.2	95.8
5	Бүрэгхангай	1924.4	991.1	1132	-140.9	114.2
6	Гурванбулаг	958.1	422.1	574.1	-152	136.0
7	Дашинчилэн	736.2	332.6	437.1	-104.5	131.4
8	Могод	600.8	264.1	319.4	-55.3	120.9
9	Орхон	1720.7	828.6	833	-4.4	100.5
10	Рашаант	1653.5	808.1	814	-5.9	100.7
11	Сайхан	710.6	321	339	-18	105.6
12	Сэлэнгэ	1011.6	445.6	565	-119.4	126.8
13	Тэшиг	1558.1	690.2	976.2	-286	141.4
14	Хангал	5024.6	2388	2522.7	-134.7	105.6
15	Хишиг-Сндер	828.3	384.6	389.6	-5	101.3
16	Хугаг-Сндер	1755.5	774.2	896.6	-122.4	115.8
17	Хялганат	1468.6	732	627.7	104.3	85.8
	<b>СУМЫН ДҮН</b>	<b>34,242.8</b>	<b>15,865.0</b>	<b>16,753.4</b>	<b>-888.4</b>	<b>105.6</b>
18	Аймгийн орлого	32,065.5	16,062.5	18,658.5	-2596	116.2
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>66,308.3</b>	<b>31,927.5</b>	<b>35,411.9</b>	<b>-3484.4</b>	<b>110.9</b>

Баяннуур, Булган сум, Хялганат тосгоны татварын орлогын төлөвлөгөө тасарч бусад сумдын орлого биелсэн байна.

## 2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **42,0** тэрбум төгрөг буюу **79,9** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **35,0** тэрбум төгрөг буюу **77,5** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **7,0** тэрбум төгрөг буюу **93,9** хувь байна. Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 13,0 тэрбум төгрөг буюу нийт зардлын 30.9%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10,5 тэрбум төгрөг буюу нийт зардлын 25,1%, хөрөнгийн зардал 7,3 тэрбум төгрөг буюу нийт зардлын 17,5 хувийг эзэлж байна. Энэхүү 3 бүлгийн зардал нийт зардлын 73,5%-ийг эзэлж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 1,632.2 сая, аймгийн ОНХСангийн гүйцэтгэл 923,5 сая, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 2,459.7 сая төгрөг байна.

## 3. Төсвийн өглөг, авлага

Орон нутгийн төсөвт байгууллагуудад нийт 238,7 сая төгрөгийн өр шинээр үүссэн байна. Үүнээс тогтмол зардлын өр 157,3 сая төгрөг байна. ЕБС-ийн дотуур байрны халаалтыг м3-ээр хэмжиж тооцох болсноос шалтгаалан халаалтын өр үүсэж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС